

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОО-2026/05-09-ШТА-НА

Чойбалсан хот
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нармандах
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4204, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4204, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn
Аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4204, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товъёг.....	5
Дүрслэлийн товъёг.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	7
--------------------------------------	---

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөөгүй байна.....8

1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй байна.....	8
1.1.1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.....	8
1.1.2. Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээг шинээр нэмж төлөвлөөгүй байна.....	9
1.1.3. Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй байна.....	9
1.1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл дэх хязгаарлалт, хориглох заалтыг мөрдөж ажилласан байна.....	9
1.2. Олон нийтээр хэлэлцүүлэх, үнийн судалгаанд үндэслэсэн байх зэрэг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.....	10
1.2.1. Олон нийтээр хэлэлцүүлсэн байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.....	10
1.2.2. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үнийн судалгаа, тооцоололд үндэслэн өртгийг төлөвлөөгүй байна.....	10
1.2.3. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилж төлөвлөсөн байна.....	11
1.2.4. Шилжих төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг төлөвлөж хуваарилсан байна.....	11

БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтаар төлөвлөгөөнд туссан 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.....12

2.1. Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангаагүй 1 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд 80.0 хувьтай зохион байгуулж дуусгасан байна.....	12
2.1.1. Захиалагч худалдан авалтын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд баталж, багцад хуваарилж, үнэлгээний хороо байгуулж ажилласан байна.....	12
2.1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж зарласан байна.....	13
2.1.3. Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд 80 хувьтай зохион байгуулж дуусгасан байна.....	14
2.1.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангаагүй 1 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.....	15
2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг хянаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.....	15
2.2.1. Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хуулийн хугацаанд хянаж шийдвэрлэсэн байна.....	15
2.2.2. Тендер шалгаруулалттай холбоотой гомдлын шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.....	16
2.2.3. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл мэдээлэлд Төрийн худалдан авах ажиллагааны газрын “Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс” хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг байна.....	16
2.3. Ил тод байдлыг хангаж ажилласан байна.....	16

2.3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.....	16
2.3.2. МУЕА-ын баталсан бодлого чиглэлийг хэрэгжүүлж ажилласан байна.....	17
БҮЛЭГ 3. Төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлээгүйгээс зорилтот үр дүн 87.5 хувьтай хэрэгжсэн байна.....	18
3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлээгүй байна.....	18
3.1.1. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтөөс болон гүйцэтгэгчээс хамаарч хугацаандаа хэрэгжихгүй нөхцөл үүссэн байна.....	18
3.1.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн тухай бүр олгосон байна.	
3.2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн ч хөрөнгө оруулалтын ажлыг хугацаа хоцроох явдал гарсаар байна.....	19
3.2.1. Барилгын тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журамд зааснаар захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулсан байна.....	19
3.2.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээж авсан байна.....	19
3.3. Хөрөнгө оруулалтын үр дүнг бодитой үнэлж дүгнэн тайлагнахгүй байна.....	20
3.3.1. Шинээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэлд авч, зориулалтын дагуу ашиглаж байна.....	20
3.3.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнах ажил хангалтгүй байна.....	21
3.3.3. Төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүн 87.5 хувьтай хэрэгжсэн байна.....	22
ДҮГНЭЛТ:.....	23-24
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:.....	25
ЗӨВЛӨМЖ:.....	26
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	27

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ДОА	Дорнод аймаг
ДОХААГ	Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХО	Хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагналын аудит
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр төсөвт өртөг өөрчлөгдсөн ТАХ /мян.төг/”	13
Хүснэгт 2	“Тендерийн үнэлгээ”	14
Хүснэгт 3	“Горим сорил хэрэгжүүлсэн байдал”	16
Хүснэгт 4	“Төсөл арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл”	17
Хүснэгт 5	“Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байдал”	20
Хүснэгт 6	“Орон нутгийн ХО-ын төсөл, арга хэмжээний хэрэгжилт”	21

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	“ТАХ-ний гүйцэтгэл”	6
Дүрслэл 2	“ТАХ-ний ангилал”	6
Дүрслэл 3	“Хөрөнгө оруулалт хийгдсэн салбар – ТАХ-ний тоогоор”	6
Дүрслэл 4	“Дорнод аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний заалттай нийцсэн байдал”	7
Дүрслэл 5	“Захиалагч худалдан авалтыг багцад хуваарилж зарласан төсөл арга хэмжээ”	11
Дүрслэл 6	“Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хуулийн хугацаанд зохион байгуулж гэрээ байгуулсан байдал”	13
Дүрслэл 7	“Төсөл, арга хэмжээний зорилтот үр дүн, хэрэгжилт”	21

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө” батлах тухай А/179 дүгээр тушаалыг үндэслэн хийнэ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт хийж зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;</i> • <i>Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;</i>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн ИТХ, Төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, сумдын Засаг дарга нар, захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэх зэрэг судалгааны арга зүйг ашиглан түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер Д.Нармандах үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор М.Ганбилэг, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитын талбарын ажлыг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайланг 05 дугаар сарын 11-ний өдөр Нийслэл дэх Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.</p>

ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ

Орон нутгийн төсвийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт шинээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хувьд 95.7 хувьтай, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд 96.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дорнод аймгийн орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шилжих 5,959.7 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 1,145.1 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Үүнээс 2025 онд шинээр хэрэгжсэн ажлын гүйцэтгэл 95.7 хувь, 2024-2025 он дамжин хэрэгжих ажлын гүйцэтгэл 96.0 хувийн хэрэгжилттэй байна. Гэрээний хэрэгжилтээр тайлант онд хэрэгжиж дууссан 17, хэрэгжээгүй 3, хэрэгжилт дутуу буюу он дамжин хэрэгжих 4 төсөл, арга хэмжээ байна.

Тайлант онд нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ангиллын хувьд барилга, байгууламж 38 хувь, их засвар, тохижилт 14 хувь, тоног төхөөмж 48 хувийг эзэлж байна. Үүнээс орон нутгийн төсөвт байгууллагад 57 хувь, улсын төсвийн байгууллагад 9 хувь, эрүүл мэндийн салбарт 5 хувь, гамшгаас хамгаалах салбарт 10 хувь, ЖДҮ-ийн салбарт 14 хувь, нийгмийн халамжийн салбарт 5 хувийн хөрөнгө оруулалтын ажил хийгджээ.


Дүрслэл 1. "ТАХ-ний гүйцэтгэл"



Дүрслэл 2. "ТАХ-ний ангилал"



Дүрслэл 3. "Хөрөнгө оруулалт хийгдсэн салбар – ТАХ-ний тоогоор"



БҮЛЭГ 1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөөгүй байна.

1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй байна.

1.1.1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 1 их засвар, 8 тоног төхөөрөмж, нийт 9 төсөл, арга хэмжээг шинээр, мөн шилжин ирсэн 4 төсөл арга хэмжээг төлөвлөн баталсан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт нь Дорнод аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөсөн байна.

Дээрх хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг нь *Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна: 6.10.11-т* гэж заасны дагуу “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Дүрслэл №4. “Дорнод аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний заалттай нийцсэн байдал”

Тусгаар тогтнолын талбайн засвар (Хэрлэн сум, 7 дугаар баг)	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний автомашин худалдан авах (Хэрлэн, Чулуунхороот сум)	Гамшиг, аюул ослын үед шаардлагатай техник хэрэгсэл (Бүсийн төв Дорнод аймгийн онцгой байдлын газар)	Хүүхэд хамгааллын хамтарсан багт автомашин	Төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин (Төрийн албаны хэрэгцээнд) багц 1, багц 2
12.3.1.2*	2.1.1.5	12.2.2.1	3.2.1.1	13.1.2.1
* Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний заалт				
8.1.1.1	8.1.2.1	12.1.2	13.1.2.1	
Арван мянган хүлэмж төслийг үргэлжлүүлэх	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтын цэгийг нэмэгдүүлэх бараа материал (Хэрлэн сум)	Дайчилгааны 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэхэд шаардлагатай бараа материал	Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж багц 1 Заалны тохижилт, багц 2 Тоног төхөөрөмж, багц 3 Бараа материал	

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө

¹ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх”

1.1.2. Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээг шинээр нэмж төлөвлөөгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/04 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад шилжүүлэн “Дорнод аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламжийн геодези, геологийн судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв” төсөл арга хэмжээг баталсан байна.

Тус төсөл, арга хэмжээг захиалагчаас MNS 4943:2011 стандартаар хэрэгжүүлэхээр ажлын даалгаврыг баталсан боловч тус стандартыг Барилга хөгжлийн төвөөс батлаагүй тул уг ажил хийгдээгүй байна.²

1.1.3. Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2} дахь хэсэгт Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: 29^{1.2.6}-д “олон нийтээр хэлэлцүүлсэн байх”, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.1³-т гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2024 оны А/486 дугаар захирамжаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналын жагсаалтыг боловсруулах, иргэд олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулахаар ажлын хэсэг томилсон ч уг захирамжийн дагуу төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, иргэд, олон нийтээс санал авч эрэмбэлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

1.1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл дэх хязгаарлалт, хориглох заалтыг мөрдөж ажилласан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 1 их засвар, 8 тоног төхөөрөмж, нийт 9 төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөн баталсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁴ дэх хэсэгт заасны дагуу ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон байна.

- “Арван мянган хүлэмж төслийг үргэлжлүүлэх” төсөл, арга хэмжээг 2 удаа зарлаж, гүйцэтгэгч шалгарсан боловч Сангийн яаманд удаа дараа гомдол гарч Сангийн яамны 2025.06.17-ны өдрийн “Гомдол хянасан тухай” 02/5995 дугаарт албан бичгийг хэрэгжүүлсэн байна.

Мөн 2 төсөл арга хэмжээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4⁵-д заасныг хэрэгжүүлэн ажилласан байна.

- “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний авто машин худалдан авах” (30.0 сая төгрөг, багц 2) төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулан ажилласан боловч бараа хүлээн авах комиссын шийдвэрийн дагуу нийлүүлэх машин нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй учир хүлээн авах боломжгүй талаар шийдвэр гаргасан тул гэрээг цуцалсан байна.

² Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

³ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;

⁴ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална:

13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;

⁵ төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

- “Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж” (10.5 сая төгрөг, багц 4) төсөл, арга хэмжээнд “Дорнын нягт хийц” шалгарч гэрээ байгуулах эрх олгосон боловч тендерийн хүчинтэй хугацаанд багтаж гэрээ байгуулаагүй, тухайн аж ахуйн нэгжээс холбогдоогүй тул гэрээ байгуулах эрхийг түдгэлзүүлсэн байна.

1.2. Олон нийтээр хэлэлцүүлэх, үнийн судалгаанд үндэслэсэн байх зэрэг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.2.1. Олон нийтээр хэлэлцүүлсэн байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2}-ын “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:”, 29^{1.2.2}-т “Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;” гэж заасан байдаг.

Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны тушаалаар батлагдсан “Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам”-ын нэгдүгээр хавсралтад барилга, байгууламжийн төвөгшлийн ангилал, хүчин чадлыг тогтоосон байна. Орон нутгийн төсвийн 2024-2025 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад төвөгшил өндөртэй, магадлалаар баталгаажуулах шаардлагатай барилга, байгууламжийн ажил тусгагдаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2}-ын “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:”, 29^{1.2.1}-д “тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;”, 29^{1.2.6} дахь “олон нийтээр хэлэлцүүлсэн байх.” гэж заасан байна.

Шилжих төсөл, арга хэмжээний жагсаалтын 12-рт батлагдсан Цагаан-Овоо суман дахь төрийн албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилгын газрын зөвшөөрөл нь тус сумын ерөнхий боловсролын сургуулийн эзэмшлийн газарт олгогдсон байна. Тус барилгын газрын эзэмших эрхийн гэрчилгээ нь ерөнхий боловсролын сургууль, ашиглалтыг хариуцагч байгууллага нь сумын ЗДТГ байх тул цаашид газрын маргаан бий болох, эд хөрөнгийн эрхийн зөрчил үүсэж болзошгүй байна.

Шинээр хэрэгжүүлэх их засвар хийх, тоног төхөөрөмж худалдан авах нийт 1,145.1 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 29^{1.2.6} дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2.2. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үнийн судалгаа, тооцоололд үндэслэн өртгийг төлөвлөөгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.8-ын “Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:”, 29.8.3-т “худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 49.4.10-т заасан судалгаа хийх;” гэж заасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь ажлын зураг, төсөв, тоног төхөөрөмжийн үнийг тооцоолохдоо ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг урьдчилан боловсруулж баталсан боловч тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг

боловсруулахдаа зах зээлийн үнийн судалгаа болон холбогдох тооцоо судалгаанд үндэслээгүй байна.

1.2.3. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-ын “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана.”, 29.3.5 дахь “нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;” гэж заасан.

Шинээр буюу 2025 онд хэрэгжиж дуусах 1,209.5 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад тусгасан бөгөөд эдгээрийн санхүүжилтийг тухайн төсвийн жилд багтаан 100 хувь санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.4. Шилжих төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг төлөвлөж хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-ын “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана.”, 29.3.5 дахь “нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;”, 2.3.6 дахь “тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.” гэж заасан.

Шилжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2024-2025 онд буюу 2 жилд багтаан санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гэвч Матад, Баянтүмэн, Цагаан-Овоо сумдын төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц барих төсөл, арга хэмжээнүүд нь төлөвлөсөн хугацаанд бүрэн дуусаагүй нь зураг, төсөвт инженерийн шугам сүлжээний төсвийг тусгаагүй баталсантай холбоотой байна.

БҮЛЭГ 2

Хөрөнгө оруулалтаар төлөвлөгөөнд туссан 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1. Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангаагүй 1 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд 80 хувьтай зохион байгуулж дуусгасан байна.


2.1.1. Захиалагч худалдан авалтын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд баталж, багцад хуваарилж, үнэлгээний хороо байгуулж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/04 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх их засвар 1, тоног төхөөрөмж 8, нийт 9 төсөл, арга хэмжээний худалдан авалтын төлөвлөгөөг батлан цахим системд нийтэлсэн байна. Харин Шилэн дансны цахим систем(shilendans.gov.mn)-д төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдах авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 06-нд буюу хугацаа хоцроон байршуулсан байгаа нь *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1⁶-т зааснаар* тогтмол мэдээлнэ гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Уг төлөвлөгөөг худалдан авах ажиллагааны цахим систем(tender.gov.mn)-д байршуулсан хугацааг тодорхойлох боломжгүй байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5⁷-д заасны дагуу 4 төсөл, арга хэмжээг багцлан хуваарилсан байна.

Дүрслэл №5. “Захиалагч худалдан авалтыг багцад хуваарилж зарласан төсөл арга хэмжээ”



Эх сурвалж: Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газрын ирүүлсэн худалдан авах ажиллагааны баримт

⁶ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

⁷ Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6⁸-ийн 6.6.3⁹, 14 дүгээр зүйлийн 14.4¹⁰, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт *Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх*: 4.1.1¹¹-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг төсвийн төвлөрүүлэн, төсвийн шууд захирагч нарт шилжүүлэх талаар заасан байна. Тайлант хугацаанд буюу 2025 онд төсвийн ерөнхийлөн захирагчаас бусад төсөв захирагч нарт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдол гараагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2¹²-т заасныг үндэслэн аймгийн Засаг даргын 2025 оны А/14, А/59, А/62 дугаар захирамжаар үнэлгээний хороодыг байгуулсан. Түүнчлэн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг таваас доошгүй буюу тус бүр 5 гишүүнтэйгээр байгуулсан нь тус хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2¹³-т заасантай нийцэж байна.

2.1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж зарласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.” гэж заажээ. Харин Сангийн Сайдын 2025 оны А/106 дугаар тушаалаар тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлагдсан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТ хууль болон Сангийн Сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу боловсруулж, зарласан байна.

2.1.3. Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд 80 хувьтай зохион байгуулж дуусгасан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр батлагдсан 1 их засвар, 8 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээнд нийт давхардсан тоогоор /багц тендер бүрээр/ 23 удаагийн тендерийг хуульд заасан хугацаанд зарлаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч 3 төсөл, арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн АИТХ-ын тогтоолоор хассан байна.

⁸ 6.6. Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагаатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

⁹ 6.6.3. төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх;


¹⁰ 14.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

¹¹ 4.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна:

¹² үнэлгээний хороо байгуулах;

¹³ ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй;

Дүрслэл 6. “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хуулийн хугацаанд зохион байгуулж гэрээ байгуулсан байдал”



Эх сурвалж: Дорнод аймгийн сум, харъяа хэлтсийн 2025 оны худалдан авах ажиллагааны тайлан

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6¹⁴-д зааснаар тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулж баталсан дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Үүнд:

Хүснэгт №1. “Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр төсөвт өртөг өөрчлөгдсөн ТАХ /мян.төг/”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг /2024-03/04 тогтоол/	Өөрчлөгдсөн дүн /2025-05-01/01 тогтоол/	Зөрүү өөрчлөлт (нэмсэн, хассан)
1.2	Шинэ			
1.2.2	Тоног, төхөөрөмж			
1.2.2.1	Арван мянган хүлэмж	345,753.5	0.0	(345,753.5)
1.2.2.2	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний авто машин худалдан авах (Хэрлэн) багц 2 Хэрлэн приус	110,000.0	80,000.0	(30,000.0)
1.2.2.3	Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж багц 4 Засвар үйлчилгээ	360,000.0	349,537.9	(10,462.1)
	Нийт дүн	815,753.5	429,537.9	(382,215.6)

Эх үүсвэр: ИТХ-ын 2024 оны 03/04, 2025 оны 05-01/01 дугаар тогтоол

Орон нутгийн төсвийн 2025 оны 1 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр шинээр хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 386.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

2.1.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангаагүй 1 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин(Төрийн албаны хэрэгцээнд)” /ДОХААГ/20250102009/-

¹⁴ тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

г 2 багц болгон нээлттэй тендер шалгаруулалт зарласан байна. 1-р багц буюу 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багцыг худалдан авах нээлттэй тендер “Соутерн инвестментс” ХХК /220,000,000 төгрөг/, “Кэтерер” ХХК /217,800,000 төгрөг/ оролцсон байна.

Тус тендерийн баримт бичигт дараах байдлаар тусгасан боловч шаардлага хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Үүнд:

Хүснэгт 2. “Тендерийн үнэлгээ”

№	Тендерийн баримт бичгийн холбогдох заалт	Хангаагүй шалтгаан
ТШЗ 18.1	Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: Үүнд: 1. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2022, 2023 онуудын дундаж нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.	Үнэлгээний хорооны 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн №3 дугаар хурлын тэмдэглэлд “Соутерн инвестмент” ХХК-ны борлуулалтын орлогыг 2024 оноор тооцож дүгнэлт гаргасан байна.
ТШЗ 19.1	Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм” ... Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023	

Эх сурвалж: Төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин (Төрийн албаны хэрэгцээнд) төсөл, арга хэмжээний ажлын баримт, Худалдан авах ажиллагааны газар, 2025 он

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна.”, 26 дугаар зүйлийн 26.9-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг хянаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

2.2.1. Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хуулийн хугацаанд хянаж шийдвэрлэсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59-р зүйлийн 59.2-т “Энэ хуулийн 30.2-т заасан үндэслэлээр гэрээ байгуулах доод хугацааг мөрдөлгүй гэрээ байгуулсан захиалагчийн шийдвэрийг мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор гомдол гаргах оролцогчийн эрхийг хязгаарлахгүй.” 59-р зүйлийн 59.8-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн гомдлын үндэслэлийн хүрээнд ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ”, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-д “Сангийн яам гомдол хянан шийдвэрлэхэд хуулийн 59.10-т зааснаар хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй асуудлаар захиалагчийг хуулийн 48.2.3-т заасан эрх, үүргийн хүрээнд хяналт тавихыг даалгасан бол захиалагч хуулийн 28.1-д зааснаар шийдвэр дахин гаргах эсэхийг шийдвэрлэж, оролцогчид мэдэгдэнэ.” 5.10-т “Захиалагч энэ журмын 5.9-д даалгасан асуудлаар үнэлгээний хорооны зөвлөмжид хяналт тавьснаар оролцогчийн тендертэй холбоотой өмнөх шийдвэрийг хүчингүй болгосон бол хуулийн 28.1, 28.2, 28.3-т зааснаар дахин шийдвэр гаргаж, мэдэгдэнэ.” гэж тус тус заасны дагуу Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хянаж шийдвэрлэсэн байна.

Сангийн яаманд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай холбоотой 2025 онд “Арван мянган хүлэмж төслийг

үргэлжлүүлэх”-тэй холбоотой 2 гомдол ирснийг дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “Батхүлэмж” ХХК-ний гаргасан гомдлыг захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн байна.
- “Бэст агро” ХХК-ний гаргасан гомдлыг сангийн яам хүлээж авахаас татгалзсан шийдвэр гаргасан байна.

2.2.2. Тендер шалгаруулалттай холбоотой гомдлын шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Сангийн яаманд гаргасан тендер шалгаруулалттай холбоотой гомдлын шийдвэрийн дагуу “Арван мянган хүлэмж төслийг үргэлжлүүлэх” төсөл, арга хэмжээний тендерийг дахин зарласан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөл, арга хэмжээнээс хасагдсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59-р зүйлийн 59.12-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг сар бүр цахим системд нийтэлнэ.” гэж заасны дагуу Сангийн яам нь tof.gov.mn сайтад тендерийн гомдол, шийдвэрлэлт цэсээр сар бүр мэдээлж ажилладаг байна.

2.2.3. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл мэдээлэлд Төрийн худалдан авах ажиллагааны газрын “Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс” хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын “Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс” ажиллаж тайлан, мэдээг албан ёсны цахим хуудсандаа мэдээлж ажилладаг байна. Орон нутгийн хэмжээнд цахим системийн бүртгэл, мэдээлэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийдэггүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49-р зүйлийн 49.4.7-д “Энэ хуулийн 22.10-т заасан хураамжийн 30 хүртэл хувийг цахим системийн найдвартай ажиллагаа, шинэчлэл сайжруулалт, аюулгүй байдлыг хангахад зарцуулах” гэж заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газар уг хуулийн заалтыг хэрэгжүүлж ажилладаг байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49-р зүйлийн 49.4.9 дэх заалт нь Төрийн худалдан авах ажиллагааны газрын чиг үүрэгт хамаарах заалт байх бөгөөд Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

2.3. Ил тод байдлыг хангаж ажилласан байна.

2.3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.1, 6.2.4, 6.3.1, 6.3.6, 6.3.7, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 6.4.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажилласан эсэх талаар Шилэн дансны нэгдсэн цахим сайтад тулгалт хийж үзэхэд дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлж, холбогдох мэдээллүүдийг хугацаандаа байршуулж ажилласан байна.

2.3.2. МУЕА-ын баталсан бодлого чиглэлд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 онд баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл” дэх орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой чиглэлд тусгагдсаны дагуу хэрэгжүүлсэн горим сорилыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №3. “Горим сорил хэрэгжүүлсэн байдал”

	Хэрэгжүүлэх горим сорил	Үр дүн, үнэлгээ		
		Тийм	Үгүй	Тайлбар
1	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй, эрх зүйн шаардлагад нийцээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь төсөвт өртөг нь өөрчлөгдөх, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт удаашрах, гүйцэтгэл нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх магадлалтай байгааг давтан шалгах, өмнөх аудитын үр нөлөөг нэмэгдүүлэх.	*		Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Тухайлбал ТАХ-дын 8 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээг зураг, төсөвт тусгаж батлаагүй байна.
2	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгосон, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчилд өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийн хангалтгүй байдалд хариуцлага тооцуулах арга хэмжээ авах.	*		Ийм асуудал илрээгүй.
3	Гэрээний үнийн дүн, магадлалаар төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ-ний гүйцэтгэлд анхаарлаа хандуулж, ИТХ-аар хөрөнгө оруулалтын төсвийг нэмж баталж байгаа процесст хяналт тавьж, төсөвт өртгийн нэмэгдэлд горим сорил хэрэгжүүлэх.	*		Магадлалаар төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ байхгүй
4	Тендер шалгаруулалтаар бий болсон төсвийн хэмнэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 ¹¹ -д заасны дагуу гэрээний бүх үе шатанд тогтвортой мөрдсөн эсэхийг шалгах. /Тухайлбал гэрээ байгуулснаас хойш ТАХ-ний төсөвт өртөгт нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд анхны тендерийн хөнгөлөлт, хэмнэлтийн дүг нэмэгдсэн өртгөөс хасаж тооцсон эсэхэд хяналт тавьж, зөрчил илэрвэл төлбөрийн акт тогтоох.	*		Хэмнэлтээр бий болсон төсвийн хэмнэлтийг орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.
5	Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг бодит хэрэгцээ, шаардлагад үндэслэн хууль, тогтоомжийн шаардлагад нийцүүлж төлөвлөж хэрэгжүүлсэн эсэхийг хянаж, үнэлэх.	*		ТАХ-ний жагсаалтыг бэлтгэхдээ байгууллагуудын саналд үндэслэсэн байна.
6	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем /PIMIS/-ээс улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татаж, аудитын нотлох баримт бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах.	*		Орон нутагт PIMIS удирдлагын системээр санхүүжилтийн үлдэгдлийг татах асуудал хэрэгжиж эхлээгүй байна.
7	Хөрөнгө оруулалтын ТАХ-нд санхүүжилтийн өр төлбөр үүсгэж дараа оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган баталж байгаа асуудалд нэмэлт горим, сорил хэрэгжүүлэх.	*		Өр авлага үүсээгүй байна.

Эх сурвалж: “Аудиторын ажлын баримт, горим сорил”

БҮЛЭГ 3

Төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлээгүйгээс зорилтот үр дүн 87.5 хувьтай хэрэгжсэн байна.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлээгүй байна.

3.1.1. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтөөс болон гүйцэтгэгчээс хамаарч хугацаандаа хэрэгжихгүй нөхцөл үүссэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих” төсөл, арга хэмжээ нь Дорнод аймгийн Матад, Баянтүмэн, Цагаан-Овоо сумдад гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна. Мөн “Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж багц1 Заалны тохижилт” төсөл, арга хэмжээ нь гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна. Хугацаандаа хэрэгжээгүй төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №4. “Төсөл арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл /мян.төг/”

№	Төсөл, арга хэмжээ	Эхлэх огноо	Дуусах огноо	Гүйцэтгэгч	Г/хувь	Гэрээний дүн	2025 онд олгосон дүн	Нийт олгосон дүн
1	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих багц2 Баянтүмэн сум	2024.05.20	2025.06.15	Дорнын танан өргөө ХХК	85.74	701,501.2	101,501.2	601,501.2
2	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих багц 5 Матад сум	2024.07.01	2025.12.15 (сунгасан)	Донж өргөө ХХК	94	709,624.2	199,982.2	668,382.2
3	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих багц 8 Цагаан-Овоо сум	2024.07.29	2025.06.15	Дорнын танан өргөө ХХК	84.27	694,343.3	225,900.3	694,350.3
4	Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж багц1 Заалны тохижилт	2025.05.29	2025.12.20	Алс зурай ХХК	48	96,235.6	45,441.5	45,441.5

Эх сурвалж: “Төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа”

“Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих” төсөл, арга хэмжээ нь төлөвлөлт буруу хийгдэж, зураг, төсөвт барилгын гадна шугам сүлжээний ажлын зардлыг тусгаагүй нь гэрээнд заасан хугацаанд дуусаагүй шалтгаан болсон байна.

“Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж багц1 Заалны тохижилт” төсөл, арга хэмжээний хувьд гэрээнд заасан хугацаандаа бараа материалыг татаагүй нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй шалтгаан болсон байна.

Энэ нь Иргэний хуулийн 350-р зүйлийн 350.1.1-т “Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх”, 351-р зүйлийн 351.1-т “Гэрээнд заасан хугацаанд, эсхүл ажлын үр дүнг хүлээн авмагц зохих журмын дагуу хөлс төлөх”, 351.1.2-т “Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. /Аудитын баг зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв./

3.1.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн тухай бүр олгосон байна.

Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д орон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгох талаар зохицуулжээ.

Хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжих 12 төсөл, арга хэмжээнээс 11 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэл, төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссын акт, дүгнэлт, гэрээ дүгнэсэн шийдвэр зэргийг үндэслэн холбогдох хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.

3.2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн ч хөрөнгө оруулалтын ажлыг хугацаа хоцроох явдал гарсаар байна.

3.2.1. Барилгын тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журамд зааснаар захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулсан байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйл 37.1.5, 37.1.15, 37.1.19, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих (Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Булган, Чойбалсан, Матад, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдтай хамтран) төсөл, арга хэмжээний үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг гэрээний дагуу хийж, фото зургаар баталгаажуулсан байна. Тусгаар тогтнолын талбайн засвар (Хэрлэн сум, 7 дугаар баг), Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж багц1 Заалны тохижилт төсөл, арга хэмжээнүүдэд гэрээнд заасны дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, фото зургаар баталгаажуулсан байна.

3.2.2. Хүлээн авах комисс нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээж авсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр төлөвлөн хэрэгжүүлсэн нийт 1,250.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй байгаа 11 төсөл, арга хэмжээ, өмнөх оноос шилжсэн 100 хувийн хэрэгжилттэй байгаа 6 төсөл арга хэмжээг тус бүрд Засаг даргын захирамжаар комисс байгуулж холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд хяналтыг хэрэгжүүлж хүлээн авсан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих (Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Булган, Чойбалсан, Матад, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдтай хамтран) багц1 Баяндун сум, багц3 Булган сум, багц4 Чойбалсан сум, багц6 Баян-Уул сум, багц7 Сэргэлэн сум, Тусгаар тогтнолын талбайн засвар (Хэрлэн сум, 7 дугаар баг), "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" ОНӨҮГ-ын харьяа барилгууд, барилгын инженерийн шугам, сүлжээг засварлах зэрэг төсөл, арга хэмжээнүүдийг үүрэг даалгаврын биелэлттэйгээр хүлээн авсан байна. Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгч нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан байна.

Тус онд шинээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 41

дүгээр зүйлийн 41.2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;” гэж заасантай нийцэж байна.

3.3. Хөрөнгө оруулалтын үр дүнг бодитой үнэлж дүгнэн тайлагнахгүй байна.

3.3.1. Шинээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэлд авч, зориулалтын дагуу ашиглаж байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн “Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:”, 4.1.24 дэх “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-ийн “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” гэж заасан.

Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон хөрөнгийг тухайн шатны төсөв захирагч нар орлогод авч, бүртгэн зориулалтын дагуу ашиглаж байна.

Шилжих хөрөнгө оруулалтаас Баянтүмэн, Матад, Цагаан-Овоо сумдын 8 айлын орон сууцны барилгын ажил дулааны шугам сүлжээг зураг төсөвт тусгаж батлаагүйгээс өнөөдрийг хүртэл ашиглалтад ороогүй байна.

3.3.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнах ажил хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2-ын “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх.” 29¹.2.5-д “тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.1.16-д “нэгтгэн тайлагнах зарчим”, 5.2.16-д “нэгтгэн тайлагнах зарчим” гэж энэ хуулийн 6.9-д заасан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Улсын Их Хуралд, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахдаа энэ хуулийн 6.7, 6.8-д заасан баримт бичигт заасан зорилго, зорилт, хүрэх үр дүнтэй уялдуулан, тухайн жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хүрэх үр дүнгийнхээ хэдэн хувьд хүрсэн, хөрөнгийн эх үүсвэр, хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэн, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу хамтад нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу тайлагнахыг;” гэж заасан.

Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч нь 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр 90 хувьтай буюу “үр дүн гарсан” гэж тайлагнан ИТХ-аас мөн “хангалттай” үнэлгээ өгчээ.

Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь түвшин 2024, зорилтот түвшин 2025 он, санхүүжилт, эх үүсвэр, хэрэгжилт гэсэн байдлаар тайлагнасан байна.

Хүснэгт №5. “Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байдал”

ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

Чойбалсан хот

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилгот түвшин 2025 он	Санхүүжилт сая төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Хэрэгжилт	Гүйцэтгэл (хувь)	Хэрэгжилт (хувь)
НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО												
САЛБАРЫН ҮР ДҮН: 1 БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.												
1.1 Боловсролын сургалтын бодлого	1.1.1 Стандартын	АХ-2.1.12. МУХТХҮЧ-21.9 МУЭГ	1.1.1.1 Сургуулийн өмнөх	Цэцэрлэгийн барилгын ажил /тухайн онд үргэлжлэх/	Тоо	2	1	1215.8	Улсын төсөв	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 11 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдаж буй 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажил хийж гүйцэтгэсэн.	100	
				Шинээр ашиглалтад орсон цэцэрлэгийн барилга 150 хүүхэд 4 баг	Тоо	-	1				Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Хэрлэн сумын 4 дүгээр багийн 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэл 100 хувьтай.	100

Эх үүсвэр: “2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн хэсгээс...”

Дүрслэл №1-д тайлагнасан төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт нь чанарын болон тоон утгыг бүрэн илэрхийлэхгүй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн “Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно.” 4.1.22-т “шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг;” гэсэн хууль зүйн нэр томъёоны утгыг хангахгүй байна.

Мөн хэрэгжилт хэсэгт шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг илэрхийлсэн харьцуулсан үр дүнг тайлагнаагүй байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд бэрхшээл үүсгэж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.17-д ““бодлогын зорилт” гэж бодлогын зорилгод нийцсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан тодорхой хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтийг;” гэж заасан боловч хөгжлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийг тус бүрээр тайлагнасан боловч 5 бодлогын зорилтын үр дүнг ерөнхийд нь үнэлж дүгнээгүй байна.

3.3.3. Төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүн 87.5 хувьтай хэрэгжсэн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.17-д “бодлогын зорилт” гэж бодлогын зорилгод нийцсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтийг;” гэж заасан.

Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 21 төсөл, арга хэмжээ /багц тус бүрээр задлахад/ хэрэгжүүлэхээр төлөвлөж, үүнээс бүрэн дууссан 17, дутуу хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээ байна.

Дүрслэл №7. “Төсөл, арга хэмжээний зорилтот үр дүн, хэрэгжилт”



17 төсөл бүрэн дууссан



4 төсөл дутуу хэрэгжсэн



Эх сурвалж: “ТАХ-ний хэрэгжилтийн судалгаа”

Барилга, байгууламж, засварын ажлыг гэрээний хугацаанд дуусгаагүй, гүйцэтгэл нь 48-94 хувьтай байгаа 2,201.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ байгаа нь бодлогын зорилтот үр дүн 87.5 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд:

Хүснэгт 6. “Орон нутгийн ХО-ын төсөл, арга хэмжээний хэрэгжилт”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн (сая.төг)	Гүйцэтгэгч	Гүйцэтгэлийн хувь	Хэрэгжилт дутуу шалтгаан тайлбар
1	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих (Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Булган, Чойбалсан, Матад, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдтай хамтран) багц2 Баянтүмэн сум	701.5	“Дорнын танан өргөө” ХХК	85.7	Гадна дулааны шугам сүлжээний ажил нь зураг, төсөвт тусгагдаагүй, 2026 онд тусгагдаж, хэрэгжихээр болсон байна. Гэрээний сунгалт хийгдсэн байна.
2	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих (Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Булган, Чойбалсан, Матад, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдтай хамтран) багц5 Матад сум	709.6	“Донж өргөө” ХХК	94	Гадна дулааны шугам сүлжээний ажил нь зураг, төсөвт тусгагдаагүй, 2026 онд тусгагдаж, хэрэгжихээр болсон байна. Гэрээний сунгалт хийгдсэн байна.
3	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих (Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Булган, Чойбалсан, Матад, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдтай хамтран) багц8 Цагаан-Овоо сум	694.4	“Дорнын танан өргөө” ХХК	84.3	Гадна дулааны шугам сүлжээний ажил нь зураг, төсөвт тусгагдаагүй, 2026 онд тусгагдаж, хэрэгжихээр болсон байна. Гэрээний сунгалт хийгдсэн байна.
4	Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж багц1 Заалны тохижилт	96.2	“Алс зурай” ХХК	48	ХАА төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, тендер оройтож зарлагдсантай холбоотой байна. Гэрээний сунгалт хийгдсэн байна.

Эх сурвалж: “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн судалгаа”

Гэрээний хугацаанд дуусгаагүй ажлуудад захиалагчийн хяналтыг сайжруулах, гүйцэтгэгч байгууллагын гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил, цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөөгүй байна:

1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй байна.

1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээг шинээр нэмж төлөвлөөгүй, он дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

2. Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй байна. Тухайлбал 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналын жагсаалтыг боловсруулах, иргэд олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулахаар ажлын хэсэг томилсон ч уг захирамжийн дагуу төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, иргэд олон нийтээс санал авч эрэмбэлсэн талаарх баримт материал байхгүй байна.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл дэх хязгаарлалт, хориглох заалтыг мөрдөж ажилласан байна.

1.2. Олон нийтээр хэлэлцүүлэх, үнийн судалгаанд үндэслэсэн байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

1. Шинээр хэрэгжүүлэх их засвар хийх, тоног төхөөрөмж худалдан авах нийт 1,145.1 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 29¹.2.6 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа зах зээлийн үнийн судалгаа болон холбогдох тооцоо судалгаанд үндэслээгүй байна.

3. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилж, шилжих төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг төлөвлөж хуваарилсан байна.

2. Хөрөнгө оруулалтаар төлөвлөгөөнд туссан 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна:

2.1. Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангаагүй 1 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд 80 хувьтай зохион байгуулж дуусгасан байна.

1. Захиалагч худалдан авалтын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд баталж, багцад хуваарилж, үнэлгээний хороо байгуулж ажилласан байна. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж зарласан байна.

2. Шинээр батлагдсан 1 их засвар, 8 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээнд нийт давхардсан тоогоор /багц тендер бүрээр/ 23 удаагийн тендерийг хуульд заасан хугацаанд зарлаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч 3 төсөл, арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн АИТХ-ын тогтоолоор хассан байна.

3. ТШЗ 18.1, 19.1-т зааса санхүүгийн чадавх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангийн шаардлагыг хангаагүй 1 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг хянаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

1. Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хуулийн хугацаанд хянаж, гомдлын шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл мэдээлэлд Төрийн худалдан авах ажиллагааны газрын “Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс” хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг байна.

2.3. Ил тод байдлыг хангаж ажилласан байна.

1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь шилэн дансны тухай хууль болон МУЕА-ын баталсан бодлого чиглэлийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3. Төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлээгүйгээс зорилтот үр дүн 87.5 хувьтай хэрэгжсэн байна:

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлээгүй байна.

1. Төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй нь төлөвлөлтийн алдаа болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан байна.

2. Шинээр хэрэгжих 12 төсөл, арга хэмжээнээс 11 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэл, төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссын акт, дүгнэлт, гэрээ дүгнэсэн шийдвэр зэргийг үндэслэн холбогдох хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.

3.2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн ч хөрөнгө оруулалтын ажлыг хугацаа хоцроох явдал гарсаар байна.

1. Барилгын тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журамд зааснаар захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээж авсан байна.

3.3. Хөрөнгө оруулалтын үр дүнг бодитой үнэлж дүгнэн тайлагнахгүй байна.

1. Шинээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэлд авч, зориулалтын дагуу ашиглаж байна.

2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнах ажил хангалтгүй байна. Тухайлбал тайлагнасан төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт нь чанарын болон тоон утгыг бүрэн илэрхийлэхгүй, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг илэрхийлсэн харьцуулсан үр дүнг тайлагнаагүй байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд бэрхшээл үүсгэж байна.

3. Барилга, байгууламж, засварын ажлыг гэрээний хугацаанд дуусгаагүй, гүйцэтгэл нь 48-94 хувьтай байгаа 2,201.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ байгаа нь бодлогын зорилтот үр дүн 87.5 хувьтай хэрэгжсэн байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:

457

МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянзүрхний гудамж, 9 дугаар баг
Харлан сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-0202, факс: 7058-0284
Цахим шуудан: asdrga@domod.gov.mn
Цахим хуудас: domod.gov.mn

2024.05.11 № 370

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгийн хэлцүүлгээр хэлцэсэн асуудлын харну тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 4 хуудастай

ЗАСАГ ДАРГА Ш.БЕГ

219679242

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгийн хэлцүүлгээр хэлцэсэн асуудлын харну тайлбар

№	Аудитын байгын шийдвэр	Харну тайлбар, санал
1	Төсөл, арга хэмжээг хяналттай болгосоруулахад иргэд, орон нутгоос олонх өмч, эрхэн засгийн үр ашг, нийгмийн ач холбогдлыг тооцож, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар татгалзсан батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлж, хяналттай хэрэгжүүлж ажиллахыг дараг төлөвлө...	Шинэ төсөл, арга хэмжээг төсөлд оруулахад төсвийн зардал, өмч, эрхэн засгийн үр ашг, нийгмийн ач холбогдлыг тооцож, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар татгалзсан батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлж, хяналттай хэрэгжүүлж ажиллахыг дараг төлөвлө...
2	Цагаан-Овоо сумын дахь Төрийн албан хаагчдын ажилтан орон сууцны барилга газар зэмшиг ажилтныг ажиллагааг хяналттай ажил хэрэгжүүлж, хяналттай үүрэг болго...	"Сумдад нэг хэрэгжээгээр мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдын зориулалт 8 албан орон сууцны барилга барих (Баянцэн, Баян-Уул, Байнгун, Булган, Чойбалсан, Матаа, Саргалан, Цагаан-Овоо сумтай хамтран) ажилын шугам сүлжээний ажилыг 2026 онд хэрэгжүүлжээр төлөвлөсөн бөгөөд барилгын ажилын дотор заслын өмч гэмтээлээс сэргийлэх дотор заслын ажилг ажиллагаанд хугацаагаа хойшлуулсан болно.
3	Тонор төлөвлөлийн техникийн тодорхойлолыг зах зээлийн үнэний судалгааг тооцож, үндэслэн судалгааг нотолж байнгын барилга барилгын материал, хавсаргах	Төсөл, арга хэмжээний ажилын үр ашг, нийгмийн ач холбогдлыг тооцож, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар татгалзсан батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлж, хяналттай хэрэгжүүлж ажиллахыг дараг төлөвлө...
4	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, шалтгуур үзүүлэлт, харуу тайланг хяналттай хэрэгжүүлж, үр дүн болго...	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, шалтгуур үзүүлэлт, харуу тайланг хяналттай хэрэгжүүлж, үр дүн болго...

дүнд хүрсэн эсэхийг үнэлж дүгнэх	Зөвлөмж, хяналттай үйл ажиллагааг хяналттай хэрэгжүүлж, үр дүн болго...	Харцуулан тайланг зөвлөмжийн хэрэгжилтэй хяналттай хэрэгжүүлж, үр дүн болго...
5	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, шалтгуур үзүүлэлт, харуу тайланг хяналттай хэрэгжүүлж, үр дүн болго...	Харцуулан тайланг зөвлөмжийн хэрэгжилтэй хяналттай хэрэгжүүлж, үр дүн болго...
6	Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн үндэслэн гүйцэтгэгчдийн биелэлтийг хуулийн хугацаанд гүйцэтгүүлж	"Сумдад нэг хэрэгжээгээр мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдын зориулалт 8 албан орон сууцны барилга барих (Баянцэн, Баян-Уул, Байнгун, Булган, Чойбалсан, Матаа, Саргалан, Цагаан-Овоо сумтай хамтран) ажилын шугам сүлжээний ажилыг 2026 онд хэрэгжүүлжээр төлөвлөсөн бөгөөд барилгын ажилын дотор заслын өмч гэмтээлээс сэргийлэх дотор заслын ажилг ажиллагаанд хугацаагаа хойшлуулсан болно.
7	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх	Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног хэрэгсэл багц 1 Заалтын тохижилт төсөл, арга хэмжээний төсөлд шалгаруулалт 2025 оны 05 дугаар сарын 12-ний өдөр нэгдсэн бөгөөд үр дүн 2025.05.15-нд хийж нийлж, 2025.05.29-нд ажилын гэрээ байгуулсан. Гэрээний үүргийг хяналттай гэрээ дүнгийн зөвлөмжийн хэрэгжилтэй хяналттай хэрэгжүүлж, үр дүн болго...

Бус. орон нутгийн хөрөнгө оруулалт, төлөвлөгөөний хяналтын дарга Ш.БЕГ, Н.Гэрэлцэр, Бус. орон нутгийн хөрөнгө оруулалт, төлөвлөгөөний хяналтын мэргэжилтэн С.Сонинго

450

МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянзүрхний гудамж, 9 дугаар баг
Харлан сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-0202, факс: 7058-0284
Цахим шуудан: asdrga@domod.gov.mn
Цахим хуудас: domod.gov.mn

2024.05.11 № 370

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны газар нь танай байгууллагаас хийгдэж буй "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар илэрсэн асуудалд тайлбар гаргаж байна.

Тус байгууллага нь ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц "Төрийн байгууллагын албан хэрэгцээнд автомашин Гертийн албаны хэрэгсэл" ДСЖААН20220102009 кодтой ажилын төндөр шалгаруулалтыг нийтдээ 4 удаа зарласан, үүнээс 2025.01.17-ны өдөр эхний урилга нийтлэсэн.

Төндөр шалгаруулалтыг зарлахдаа төндөр шалгаруулалтын баримт бичигт /авиадийн хүснэгт 18.1/ оролцогчийн санхүүгийн чадах буюу "сүүлийн гурав хуртал жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл"ийг шаардахдаа "сүүлийн 2022, 2023 оны орлогын буйдаг" гэж шаардсан нь санхүүгийн тайланг дараа оны 02.10-ны өдрийн дотор баталгаажуулан тайлагнасан байх хугацааг харгалзан тусгаасан, ижил төстэй ажилын тухайд бон санхүүгийн тайланг-агийн хугацаа хавсархгүй тул "сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онуудыг" гэж тусгаасан. Тухайлбал, энэ шаардлагыг тусгахаар 02.20-ны өдрөөс өмнө /тодруулаа гарах, алдааг залруулах хугацааг тооцож 2.20 хуртал/ нэгдэх бараа, ажил, үйлчилгээний тухайд сүүлийн 3 жилийн /агууламтад нь тухайн оны өмнөх он буюу 2024 он биш тухай өмнөх 3 хүртлэх жилийн борлуулалтын орлогыг, 02.20-ны өдрөөс хойш нэгдэх бараа, ажил, үйлчилгээний тухайд сүүлийн 3 жилийн буюу тухайн онд өмнөх 3 хүртлэх жилийн борлуулалтын орлогыг төндөр шалгаруулалтын баримт бичигт зааж ирсэн, харин ижил төстэй ажилын тухайд тухайн онд өмнөх 3 хүртлэх жилийн буюу 2022, 2023, 2024 онуудын мэдээллийг шаардах байдалар тусгаж ирсэн.

Тухайн төндөрт 1 дүгээр багцад 1 оролцогч буюу "Соутерн инвестментс" ХХК нь оролцсон ч татварын өртэй, дээр дурдсан онуудад борлуулалтын орлогын мэдээлэл байхгүй тул татгалзсан байна. Дараа буюу 2 дэх удаагийн төндөрийг зарлахдаа /2025.02.17-ны өдөр/ тухайн онд өмнөх 3 хүртлэх жилийн мэдээллийг үнэлэхээр төндөр шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулалтыг зарласан, түүнийг үнэмлэж, харин үнэмлээс 02.20-ны өдрөөс хойш нэгдсэн бараа, ажил, үйлчилгээ байсан тул хуулийн 16.3-д заасан "сүүлийн 3 жилийн..." гэсэн аялалтын дагуу 2024 оны борлуулалтын орлогын мэдээлэлд үнэлгээ хийсэн байна, үүнийгээр хурлын тэмдэглэлд мөн ажил дурдсан байна.

Энэ алдаагаа "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар аж мэдсэн.

Иймд дээрх алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах болно.

Түүнчлэн тус Үнэлгээний хорооны дарга Б.Саранчимэг нь би нийтийн албан тушаалтын үүргээ чанд ухамсарлан энэхүү тайлбарыг үзэн зөв гаргасан болохоо үүгээр илэрхийлж баталгаажуулж байна.

Мөн дээрх оролцогчийн миний дүгээс наран ижил хувийн ашиг сонирхол байхгүй, мөн түүнд давуу байдал үүсгэсэн зүйл байхгүй гэдгээ үүгээр илэрхийлж байна.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

2024.05.11 № 370

Тайлбар гаргах тухай

Түүнчлэн тус Үнэлгээний хорооны дарга Б.Саранчимэг нь би нийтийн албан тушаалтын үүргээ чанд ухамсарлан энэхүү тайлбарыг үзэн зөв гаргасан болохоо үүгээр илэрхийлж баталгаажуулж байна.

Мөн дээрх оролцогчийн миний дүгээс наран ижил хувийн ашиг сонирхол байхгүй, мөн түүнд давуу байдал үүсгэсэн зүйл байхгүй гэдгээ үүгээр илэрхийлж байна.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.САРАНЧИМЭГ

Саналд өгсөн тайлбар:

1. Тайлангийн төсөлтэй холбоотой аймгийн Засаг даргаас ирүүлсэн тайлбарт өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах талаар дурдсан байх тул шийдвэрт өөрчлөлт оруулахгүйгээр дүгнэлт, зөвлөмжийг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.
2. Худалдан авах ажиллагаатай холбоотой тайлангийн 2.1.4 дэх хэсэгт аймгийн Засаг дарга болон ХААГ-ын даргаас ирүүлсэн тайлбарыг аудитын багаар хэлэлцэн үнэлж, аудитын шийдвэрийг өөрчилж, алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах төсөв захирагч нарт зөвлөж байна. Үүнд:

1. Аймгийн Засаг дарга Ш.Ёлд:

1. Төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулахдаа иргэд, олон нийтээс санал авах, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг урьдчилан тооцоолж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу төлөвлөх,

2. Цагаан-Овоо суман дахь Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилгын газар эзэмших эрхийг ашиглагч байгууллагад шилжүүлж, хариуцуулах ажлыг зохион байгуулж, сумын удирдлагуудад үүрэг болгох,

3. Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг зах зээлийн үнийн судалгаа, тооцоололд үндэслэн боловсруулж, нотлох баримтаар баталгаажуулан холбогдох баримт материалд хавсаргах,

4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй харьцуулан тайлагнаж, бодлогын зорилт тодорхой үр дүнд хүрсэн эсэхийг үнэлж дүгнэх,

5. Захиалагч, зохиогчийн хяналтыг сайжруулах замаар төсөл, арга хэмжээг зорилтот үр дүнд хүргэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах,


6. Иргэний хуулийн 350 дугаар зүйлийг үндэслэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хуулийн хугацаанд хангуулах.

Аудитаар нийт 1,365.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 220.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1,145.1 сая төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгөв.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Анхаарах зүйл: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг **аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

Хэлтэс: 05-сарын 11, 2025
Дугаар: А/175
Тайлан хаяг: Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- "Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
- Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
- Аудитын тайланг Нийслэл дэх төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон аудитад хамрагдсан бусад байгууллагад тус тус хүргүүлсүгэй.
- Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.



Б.БСЛОРТУУЛ

2125020055



Дарга, Тэргүүлэх Аудиторын 2026 оны 05 дугаар сарын 11 нийтлэлийн үйл ажиллагааны хавсралт

Албан шаардлагын жагсаарт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Нийцлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1.	Аймгийн Засаг дарга	ДОА-2026/05-09-ШТА-НА	Зөрчил арилгах тухай /ХАА/	220,000,000
	Нийт дүн			220,000,000

---oOo---

